



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/707

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааг
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11/41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжих Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч 4 суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулан, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Ю.Идэрцогт/-т даалгасугай.

3. Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Нийслэлийн Засаг даргын 2013 оны
07 дугаар сарын 03 өдрийн
А/207 дугаар захирамжийн
Хавсралт

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ ХЭМЖИГЧ 4 СУУРИН
АВТОМАТ ХАРУУЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ
ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чада байршил	Хугацаа	2013 онд санхүүжих
1.	Орчны агаар дахь озон хэмжигч төхөөрөмж /4ш/	2013	280.0
2.	Орчны агаар дахь азотын ислүүд Хэмжигч төхөөрөмж /4ш/	2013	280.0
	ДҮН		560.0



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/743

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 11/41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/707 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч 4 суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг нийслэлийн Засаг даргын өмнө хариуцан ажиллахыг нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Л.Бат-Эрдэнэ-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ

Н.БАТАА

111020002943

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
08 дугаар сарын 08-ны өдрийн
А.19.2/5 дугаар захирамжийн
хавсралт

УХБ0011 9077243

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ ХЭМЖИГЧ 4 СУУРИН АВТОМАТ
ХАРУУЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО

Дарга:	Т.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	М.Баярмаа	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн
	Х.Галымбек	Нийслэлийн Агаарын чанарын албаны орлогч
	Д.Мандал	Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, 10 дугаар хороолол 54-31 тоотын оршин суугч, иргэн /зөвшилцснөөр/
Нарийн бичгийн дарга:	С.Мөнхсүлд	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2013 ОНЫ 08 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨГИЙН
 А/743 ДУГААР ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН
 ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

11.05

Дугаар №06

Улаанбаатар хот

Гүйцэтгэгч сонгох, гэрээ байгуулах

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн зөвлөмжийг үндэслэн **ЗӨВЛӨХ НЬ:**

Нэг. Гендерийн үнэлгээний хорооны 2013 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр болсон хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн "Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч суурин автомат харуулын тоног төхөөрөмж шинэчлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгох нь гаруулахад хамгийн сайн үндэслэсэн дүрмийг барууллагатай гэрээ байгуулахыг зөвлөсүгэй.


Багцын нэр, дугаар	Шалгарсан байгууллагын нэр	Үнийн санал /төгрөгөөр/
"Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч суурин автомат харуулын тоног төхөөрөмж нийлүүлэх" ажил Багцын дугаар: НХААГ-13/0299	ИНТЕРСАЙНС ХХК	500.000.000

Хоёр. Дээрх байгууллагатай Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлгээ худалдан авах тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулах гүйцэтгэлд хяналт тавих ажлынхыг Нийслэлийн Агаарын чанарын албаны дарга /Ч.Батсайхан/-д үйлгээсүгэй.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ГИШИҮҮД:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:




Т.БАТЖИРДЭН



М.БАЯРМАА



Х.ГАЛЫМБЕК





Д.МАНДАЛ



С.МӨНХСҮЛД

БАТЛАВ

ЗӨВШӨӨРСӨН



ГЭРЭЭНИЙ НЭР: НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ ХЭМЖИГЧ СУУРИН
АВТОМАТ ХАРУУЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ АЖИЛ

Дугаар: НХААГ-0299

Улаанбаатар хот

Нэг талаас **НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБА** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"ИНТЕРСАЙНС" ХХК** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараахи зүйлийг харилцан тохиролцож 2013 оны 11 сарын 18 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.


1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь "Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил" НХААГ-0299 500,000,000.00 (таван зуун сая төгрөг) (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь 500,000,000.00 (таван зуун сая) төгрөгийг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод дурьдсан нэр төрлийн барааг 2013 оны 11 дугаар сарын 18-ны өдрөөс 2014 оны 11 дугаар сарын 15-ны дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай бичиг баримт;

Тендер ба үнийн хуваарь;
 Гэрээний тусгай нөхцөл;
 Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Нийслэлийн Агаарын чанарын
 албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн
 дарга

 Д.ДАВААДОРЖ

Нийслэлийн Агаарын Чанарын
 Албаны нягтлан бодогч

 П.АРИУНАА

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй
 дүүрэг, Нийслэлийн төр захиргааны
 нэгдсэн байр Хангарьд ордон, 401
 тоот
 Утас: 976-11-314876 /Факс: 976-11-
 324632

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Интер Сайнс ХХК-ийн
 ерөнхий нягтлан бодогч

 Д.УЯНГА

Интер Сайнс ХХК-ийн
 Инженер

 Д.ДУВААНЖАВ

Нийлүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх
 дүүрэг, Энхтайваны өргөн
 чөлөө-46
 Утас: 976-7015-8002
 Факс: 976-7015-8001
 Банк: Худалдаа Хөгжлийн Банк
 Данс: 404-189-213

**ГЭРЭЭНИЙ НЭР: НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДЛЫГ ХЭМЖИГЧ СУУРИН
АВТОМАТ ХАРУУЛЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ АЖИЛ**

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ: БАТАЛГААТ ХУГАЦАА

Улаанбаатар хот

Энэхүү хавсралт нь нэг талаас **НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБА** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **“ИНТЕРСАЙНС” ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) нарын 2013 оны 11 сарын 18 -ны өдөр байгуулсан **“Нийслэлийн агаарын бохирдлыг хэмжигч суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын гэрээ”**-ний салшгүй хэсэг мөн болно.

Ерөнхий нөхцөл

Нийлүүлэгч тал тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснөөс хойш 12 сарын баталгаа гаргаж өгнө. Баталгаат хугацааны дотор захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарсан гэмтлээс бусад гэмтлийг үнэ төлбөргүй засварлана.

Баталгааны нөхцөл

Тухайн барааны баталгаат засварын хугацаанд гарсан эвдрэл, гэмтэл нь үйлдвэрийн шалтгаантай тохиолдолд уг барааг хэвийн ажиллагаанд оруулан үнэ төлбөргүй засварлана.

Зөвхөн Интер Сайнс ХХКомпаний эрх бүхий ажилтан худалдан авсан барааны лац, баталгааг шалган үзэх, түр хүчингүй болгох бүрэн эрхтэй байна. Баглаа боодол болон бусад дагалдах эд ангиудад энэхүү баталгаа үйлчлэхгүй.

Баталгаат хугацаанд эвдэрч, гэмтэлтэй болсон барааг Интер Сайнс ХХКомпанид тамгатай баталгаат засварын хуудсыг үндэслэн хүлээн авна.

Дараах тохиолдлуудад гарсан эвдрэл, гэмтлийг хариуцахгүй:

- Барааны ашиглах заавар зөрчигдсөн.
- Баталгаат засварын хугацаанд тухайн төхөөрөмж, эд ангиудыг эрх бүхий бус засвар үйлчилгээний төв, хувь хүнээр засуулах гэж оролдсоноос үүдэлтэй эвдрэл, гэмтэл.
- Дотор гадны биет, бодис, ус, шингэн орсноос үүдсэн гэмтэл.
- Байгалийн гамшиг, гал түймэр, цахилгааны хэлбэлзэл, иргэний үймээн самуун болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэл, гэмтэл.
- Гадны механик үйлдлээс учирсан эвдрэл, гэмтэл.
- Хэвийн элэгдэл хуучралттай холбоотой эвдрэл, гэмтэл.

Дараах нөхцөлд баталгааг хүчингүйд тооцно:

- Лацыг хөндсөн. Баталгаат засварын хугацаанд тухайн төхөөрөмж, эд ангиудыг эрх бүхий бус засвар үйлчилгээний төв, хувь хүнээр засуулсан.
- Уг баталгааны хуудсыг өөрчилсөн, дуурайлган үйлдсэн, засварласан.

- Баталгааны хуудсыг хаяж үрэгдүүлсэн.
- Баталгааны хугацаа дууссан.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Нийслэлийн Агаарын чанарын
албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн
дарга

 Д.ДАВААДОРЖ

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Нийслэлийн төр захиргааны
нэгдсэн байр Хангарьд ордон, 401
тоот
Утас: 976-11-314876 /Факс: 976-11-
324632

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Д.ДУВААНЖАВ

Нийлүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, Энхтайваны өргөн
чөлөө-46
Утас: 976-7015-8002
Факс: 976-7015-8001